




TIMES HIGHER EDUCATION ДЭЛХИЙН ИХ СУРГУУЛИУДЫН ЭРЭМБЭ

(WUR - WORLD UNIVERSITY RANK)

АРГАЧЛАЛ - 2025

МУИС-ИЙН ТУРШЛАГА

МУИС-ийн Ажлын хэсгийн ахлагч,
дэд профессор Н.Пүрэвцогт
2025-04



Санал асуулга - THE

11-2 сарыг дуустал

Өгөгдөл оруулах - ДБСБ

1-3 сарыг дуустал

Нөхцөл хангасан эсэхийг
тодорхойлох - THE

4-6 сар


Эрэмбийн
цагалбар

Эрэмбэ зарлах - THE

10 сар

Эрэмбийн тооцоолол - THE

4-9 сар



Агуулга

1

Эрэмбэлүүлэх нөхцөл

- ДБСБ-ын эрэмбэд тавих нөхцөл
- ШУ-ны салбарын эрэмбэд тавих нөхцөл

2

Өгөгдөл оруулах

- Өгөгдлийн төрөл
- Тооцох хугацаа
- Цахим систем

3


Эрэмбийн тооцоолол

- Метрик
- Аргачлал

4

Эрэмбэ зарлах

- МУИС-ийн үр дүн
- Зарим метрикийн дэлгэрэнгүй






World
University
Rankings 2025

THE World University Rankings 2025:

1. ЭРЭМБЭД ОРОХ НӨХЦӨЛ




ДБСБ-ын эрэмбэд тавих нөхцөл (WUR)

- 1 5 жилд нийт 1000+, жил тус бүр 150+ ӨГҮҮЛЭЛТЭЙ БАЙХ
- 2 БАКАЛАВРЫН ТҮВШНИЙ СУРГАЛТ ЭРХЭЛДЭГ БАЙХ
буюу ДАН АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТ ЭРХЭЛДЭГГҮЙ БАЙХ
- 3 ШИНЖЛЭХ УХААНЫ 1 САЛБАРААР ДАГНААГҮЙ БАЙХ
(Нийт өгүүллийн 80%-с илүү нь нэг салбарт хамаарахгүй байх).
- 4 СУРГУУЛИЙН НИЙЛБЭР МЭДЭЭЛЛИЙГ ИЛГЭЭХ
(Зөвхөн аль нэг салбарын мэдээллийн илгээж болохгүй)
- 5 ЗААВАЛ МЭДҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС 2-С ИЛҮҮ УТГЫГ ХООСОН ЭСВЭЛ
БОЛОМЖГҮЙ БАЙДЛААР МЭДҮҮЛЭХГҮЙ БАЙХ
- 6 ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР ТУС БҮРИЙН БОСГЫН АЛЬ НЭГИЙГ ЗААВАЛ
ХАНГАЖ БАЙХ
- 7 “ҮНЭЛГЭЭНИЙ ОРУУЛАХ БОЛОМЖГҮЙ” ЖАГСААЛТАД ОРООГҮЙ БАЙХ

(5) ЗААВАЛ МЭДҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

1. Багш
2. Гадаад багш
3. ЭШ-ний ажилтан
4. Суралцагч
5. Гадаад суралцагч
6. Солилцооны оюутан
7. Бакалаврын төгсөгч
8. Докторын төгсөгч
9. Сургуулийн нийт орлого
10. Судалгааны орлого
11. Үйлдвэрлэл,
худалдаанаас олж буй
орлого



(6) ШУ-ны 11 салбарын босго

Physical Sciences -500

mathematics and statistics
chemistry
physics and astronomy
environmental science
earth and planetary sciences

Clinical and Health - 500

health
pharmacology
nursing
medicine

Computer Science - 500

computer and information science
software Engineering
information Systems
telecommunications

Life Sciences - 500

veterinary
immunology and microbiology
neuroscience
biochemistry, genetics, molecular biology
agricultural and biological sciences

Arts and Humanities - 250

Art and humanities

Business and Economics - 200

business
economics
management
accounting
finance

Education - 100

education

Engineering - 500

engineering
chemical engineering

Psychology - 150


psychology

Law - 100

law

Social Sciences - 200


social sciences
decision sciences



ШУ-ны салбарын эрэмбэд тавих нөхцөл

- ДБСБ-д тавих шаардлагыг хангасан байх
- Салбарын ЭШ-ний бүтээлийн босго хангасан байх
- Нэмэлт нөхцөл:

ШУ-ны салбар	Бүтээлийн тоо	Нийт багшид эзлэх хувь	Багшийн абсолют тоо
Arts and Humanities	250	5%	50
Business and Economics	200	5%	50
Clinical and Health	500	5%	50
Computer Science	500	1%	20
Education	100	1%	20
Engineering	500	4%	40
Law	100	1%	20
Life Sciences	500	5%	50
Physical Sciences	500	5%	50
Psychology	150	1%	20
Social Sciences	200	4%	40






World
University
Rankings 2025

THE World University Rankings 2025:

2. ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ



Өгөгдлийн төрөл




А. Академик өгөгдөл
Их сургуулиудаас



Б. Нэр хүндийн судалгаа
Судлаачдаас (via THE)



В. ЭШ-ний өгөгдөл
Elsevier-с (via THE)



Өгөгдлийг тооцох хугацаа

Зарлах оноос 3 жилийн өмнөх өгөгдөл ашиглана.

Жишээлбэл:

THE World University Rankings 2025 эрэмбэд:

- **Академик өгөгдөл** – 2021-22 оны хичээлийн жил, 2022 оны санхүүгийн жил
- **Нэр хүндийн судалгаа** – 2023 ба 2024 онд явагдсан судалгааны үр дүн
- **ЭШ-ний өгөгдөл** – Бүтээл: 2019-2023, Эшлэл 2019-2024
- Эрэмбэд орохоор мэдүүлж, эрэмбэ бодогдох жил: 2024

А. Академик өгөгдөл (via.University)

Багш, ЭША

- 1 Нийт багшийн тоо
- 2 Гадаад багшийн тоо
- 3 Эмэгтэй багшийн тоо
- 4 Эрдэм шинжилгээний ажилтны тоо

Суралцагч

- 5 Нийт суралцагчийн тоо
- 6 Гадаад суралцагчийн тоо
- 7 Эмэгтэй суралцагчийн тоо
- 8 Бакалаврын түвшний суралцагчийн тоо
- 9 Магистрын түвшний суралцагчийн тоо
- 10 Докторын түвшний суралцагчийн тоо
- 11 Оюутан солилцоогоор явсан суралцагчийн тоо

Төгсөгч

- 12 Бакалаврын түвшний төгсөгчийн тоо
- 13 Докторын түвшний төгсөгчийн тоо
- 14 Судалгааны докторын төгсөгчийн тоо
- 15 Мэргэжлийн докторын төгсөгчийн тоо

Орлого

- 16 Их сургуулийн нийт орлого
- 17 Судалгааны орлого
- 18 Үйлдвэрлэл, худалдааны орлого



А. Академик өгөгдөл

Их сургуулиудаас

- Сургуулийн нэгдсэн дүнг заавал мэдүүлэх
 - Нэгдсэн дүнгээр Их сургуулийн нийт эрэмбэ бодогдоно.
- ШУ-ны 11 салбараар заавал ангилж мэдүүлэх
 - Салбарын нөхцөл хангасан тохиолдолд тухайн салбараар эрэмбэлэгдэнэ.

Б. Нэр хүндийн судалгаа (via. THE)

Хэзээ:

- Жил бүрийн 11 сараас 3 сарын хугацаатай.

Хэн:

- Сүүлийн 5 жилд бүтээл хэвлүүлсэн, ядаж нэг эшлэлтэй байх
- Улс, бүс нутаг, судлаачдын тоотой пропорцолж сонгодог. Жигд хариулт ирээгүй тохиолдолд үнэлгээнд салбар болон улсаар жинлэнэ.

Яаж:


- 12 хэлээр үүсгэсэн урилга явуулна
- Цахимаар авна. Хариулт нь нууцлалтай

Агуулга: 2 үндсэн чиглэлээр хамгийн ихдээ 15 ИС сонгохоор

- Таны чиглэлээр хамгийн сайн судалгаа хийдэг их сургууль
- Таны чиглэлээр хамгийн сайн сургалт явуулдаг их сургууль



Б. Нэр хүндийн
судалгаа
Судлаачдаас



В. ЭШ-ний өгөгдөл

- Их сургуулиуд өөрсдөө мэдүүлэхгүй.
- Elsevier (Scopus) – ийн өгөгдлийн сангаас THE авна.
- Аргачлалд ашиглагдаж буй ЭШ-ний өгөгдлүүд
 - Бүтээлийн тоо
 - Гадаадтай хамтарсан бүтээлийн тоо
 - Патентад эшлэгдсэн бүтээлийн тоо
 - Эшлэлийн тоо
- ❖ Улсын хүн амын тоо



В. ЭШ-ний өгөгдөл *Elsevier-с (via THE)*

ЭШ-ний бүтээл:

- journal articles
- article reviews
- conference proceedings
- books and book chapters

ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ

Өгөгдөл мэдүүлэх:

- Цахим системээр мэдүүлнэ.
<https://www.timeshighereducation.com/wur/portal>
 - Урьдчилан холбогдож нэвтрэх эрх авсан байна.
- Жил бүрийн 1-3 сарыг дуустал хугацаанд нээгдэнэ.
- Өгөгдлийг “нэгдсэн” болон “ШУ-ны 11 салбараар ангилсан”-аар оруулна.

Хураамж:

- Эрэмбийн нөхцөл хангасан гэж үзэж буй бүх сургуульд нээлттэй буюу төлбөргүй.




World
University
Rankings 2025


THE World University Rankings 2025:

3. ЭРЭМБИЙН ТООЦООЛОЛ

- Метрик
- Аргачлал



The World University Rankings - метрикүүд



СУРГАЛТ - TEACHING (29.5%)

1. Сургалтын нэр хүнд (Teaching reputation) (15%)


Тодорхойлолт	Сургалтын нэр хүндийн талаарх санал асуулгын үр дүн THE байгууллагаас сонгогдсон судлаачдад судалгааны асуумжийг илгээж, тэднээс өөрсдийн салбартаа сургалт болон/эсвэл судалгаагаараа хамгийн шилдэг гэж үздэг 15 их сургуулиудыг сонгуулж, санал асуулгыг бөглүүлдэг бөгөөд сүүлийн хоёр жилд авсан нэр хүндийн судалгааны үр дүнг ашиглана. Жил бүрийн тооцоололд судалгаанд оролцогчдын тархалтыг жигд төлөөлүүлэхийн тулд тухайн саналын тоог мэргэжлийн чиглэл, улс орноор жинлэж тооцдог. Зөвхөн тэгээс ялгаатай утгатай өгөгдлүүдийг логарифм ашиглан стандартчилна. Харин санал аваагүй их сургуулиуд энэ үзүүлэлт дээр тэг оноо авна. Санал асуулгын тоо болон үнэлгээнээс хамаарна.
Томьёо	$M_1 = f(P_{23})$
Ашиглах өгөгдөл	P23 Сургалтын нэр хүндийн талаарх судалгаа

2. Суралцагч – багшийн харьцаа (Student-staff ratio) (4.5%)

Тодорхойлолт	Нэг багшид ногдох суралцагчийн тоо Суралцагч-багшийн харьцааг бүтэн цагтай дүйцэх (FTE) академик албан тушаал хашиж буй нийт багшийн тоог, бүх түвшний болон бүх хөтөлбөрийн идэвхтэй суралцаж буй суралцагчийн тоонд хувааж тодорхойлно.
Томьёо	$M_2 = \frac{P_5}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P5 Суралцагчийн тоо P1 Багшийн тоо

3. Докторын болон бакалаврын төгсөгчийн харьцаа (2%)

Тодорхойлолт	Докторын болон бакалаврын төгсөгчийн харьцаа Докторын төгсөгчдийн тоог бакалаврын төгсөгчдийн тоонд харьцуулна.
Томьёо	$M_3 = \frac{P_{13}}{P_{12}}$
Ашиглах өгөгдөл	P12 Бакалаврын төгсөгчийн тоо P13 Докторын төгсөгчийн тоо




СУРГАЛТ - TEACHING (29.5%)

4. Докторын төгсөгч – багшийн харьцаа (5.5%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох докторын төгсөгчийн тоо Энэхүү үзүүлэлт нь их сургуулийн дараагийн үеийн багш, судлаачдыг бэлтгэхэд хэрхэн анхаарч буйг илтгэхээс гадна, ахисан түвшний сургалтын хэмжээ, хөгжлийг харуулна. Тус үзүүлэлтийг нийт докторын төгсөгчийн тоог багшийн тоонд хувааж гаргана. Докторын төгсөгчийн тоо салбар бүрд ялгаатай байдаг тул их сургуулийн мэргэжлийн чиглэлийн бүтцийг харгалзан үзнэ.
Томьёо	$M_4 = \frac{P_{13}}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P13 Докторын төгсөгчийн тоо P1 Багшийн тоо

5. Нийт орлого (Institutional income) (2.25%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох их сургуулийн орлого Энэхүү орлогын хэмжүүр нь их сургуулийн ерөнхий төлөв байдлыг илтгэхээс гадна, суралцагч болон ажилтнуудад зориулсан дэд бүтэц, тоног төхөөрөмжийн боломжийн талаар өргөн хүрээний ойлголт өгнө. Энэхүү үзүүлэлт нь байгууллагын нийт орлогыг нийт багшийн тоонд хувааж гаргана.
Томьёо	$M_5 = \frac{P_{16}}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P16 Нийт орлого P1 Багшийн тоо




СУДАЛГААНЫ ОРЧИН - RESEARCH ENVIRONMENT (29%):

6. Судалгааны нэр хүнд (Research reputation) (18%):

Тодорхойлолт	Судалгааны нэр хүндийн талаарх санал асуулгын үр дүн Энэхүү үзүүлэлт нь их сургуулиудын судалгааны нэр хүндийн талаарх хүлээлт, үнэлэмжийг судалдаг. сүүлийн хоёр жилд авсан нэр хүндийн судалгааны үр дүнг ашиглана. Жил бүрийн тооцоололд судалгаанд оролцогчдын тархалтыг жигд төлөөлүүлэхийн тулд тухайн саналын тоог мэргэжлийн чиглэл, улс орноор жинлэж тооцдог. Зөвхөн тэгээс ялгаатай утгатай өгөгдлүүдийг логарифм ашиглан стандартчилна. Харин санал аваагүй их сургуулиуд энэ үзүүлэлт дээр тэг оноо авна. Санал асуулгын тоо болон үнэлгээнээс хамаарна.
Томьёо	$M_1 = f(P_{24})$
Ашиглах өгөгдөл	P24 Эрдэм шинжилгээний нэр хүндийн талаарх судалгаа

7. Судалгааны орлого (Research income) (5.5%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох судалгааны орлого Энэхүү үзүүлэлт нь мэргэжлийн чиглэлээр жигнэгдсэн судалгааны орлогыг нийт мэргэжлийн чиглэлээр жигнэгдсэн багшийн тоонд хувааж гаргах бөгөөд тооцоолсны дараа стандартчилна. Энэ үзүүлэлт нь улсын бодлого болон эдийн засгийн нөхцөлөөс хамаарч, заримдаа маргаантай үзүүлэлт гэж үздэг. Орлого нь дэлхийн түвшний судалгааг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй, ихэнх нь өрсөлдөөнтэй, хамтын үнэлгээнд суурилдаг учраас энэхүү үзүүлэлтийг зайлшгүй байх ёстой гэж үзсэн. Энэ үзүүлэлтийг тооцоолохдоо байгууллагын мэргэжлийн чиглэлийн онцлогийг харгалзан үздэг.
Томьёо	$M_7 = \frac{P_{17}}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P17 Эрдэм шинжилгээний ажлын орлого P1 Багшийн тоо




СУДАЛГААНЫ ОРЧИН - RESEARCH ENVIRONMENT (29%):

8. Судалгааны бүтээмж (Research productivity) (5.5%)

Тодорхойлолт	Нэг багш, ЭШ-ний ажилтанд ногдох ЭШ-ний бүтээлийн тоо. Elsevier-ийн Scopus өгөгдлийн санд бүртгэгдсэн академик сэтгүүлүүдэд судлаачдын нийт хэвлүүлсэн бүтээлийн тоог нийт багш, эрдэм шинжилгээний ажилтны тооны нийлбэрт харьцуулна. Энэ үзүүлэлт нь чанартай судалгааны бүтээл хэвлүүлэх чадварыг илэрхийлнэ.
Томьёо	$M_8 = \frac{P_{19}}{P_1 + P_4}$
Ашиглах өгөгдөл	P1 Багшийн тоо P4 Эрдэм шинжилгээний ажилтны тоо P19 Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо

Нэмэлт:

2018 оноос эхлэн их сургууль багш байхгүй чиглэлээр бүтээл хэвлүүлсэн бол түүнийг тооцох аргачлалыг боловсруулсан. Тухайн ЭШ-ний салбарт судалгааны бүтээл байгаа ч багшгүй бол эдгээр бүтээлүүдийг багш байгаа чиглэлүүдэд хуваарилна. Үүнийг тухайн чиглэлд байгаа багшийн тоо болон тухайн чиглэлийн багшид ногдох медиан бүтээлийн тоог харгалзан пропорционалиар тооцно. Дахин хуваарилах бүтээлийн хувьд нийт бүтээлийн 10%-ээс хэтрэхгүй байх дээд хязгаартай.




СУДАЛГААНЫ ЧАНАР - RESEARCH QUALITY (30%):

9. Эшлэлийн хэмжээ (Citation impact) (15%):

Тодорхойлолт	Эрдэм шинжилгээний бүтээлийн дундаж эшлэл Их сургуулийн хэвлэгдсэн нийт бүтээлийг дунджаар хэдэн удаа иш татсаныг тодорхойлох замаар ЭШ-ний бүтээлийн нөлөөллийг үнэлнэ. 6 жилийн үзүүлэлтийг ашиглана. ЭШ-ний салбар бүрийн эшлэлийн хэмжээ харилцан адилгүй байдаг тул өгөгдлийг салбараар нормчилж тооцоолно.
Томьёо	$M_9 = \frac{P_{22}}{P_{19}}$
Ашиглах өгөгдөл	P22 Эшлэлийн тоо P19 Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо

10. Судалгааны чанар (Research strength) (5%):

Тодорхойлолт	Салбар бүрээр 75%-ийн прецентильд хамаарах эшлэл Энэ үзүүлэлт нь судалгааны чанарыг тодорхойлох бөгөөд нийт бүтээлд хэт өндөр болон хэт бага эшлэгдсэн өгүүллүүдийн нөлөөг үл харгалзах зорилготой. Дараах 2 алхмын дагуу тооцоолно. 1. Салбараар жинлэсэн эшлэл (FWCI - Field Weighted Citation Impact)-ийг дараах байдлаар тодорхойлно. Тухайн салбарын ЭШ-ний бүтээлийн эшлэлийг тухайн салбарын дундаж эшлэлд харьцуулж тооцно. FCWI=1.00 – салбарын дундаж эшлэлтэй ижил түвшинд FCWI=1.48 – салбарын дундаж эшлэлээс 48% илүү FCWI<1.00 – салбарын дундаж эшлэлээс бага эшлэлтэй 2. Салбараар жинлэсэн эшлэлийн тархалтын 75 хувийн прецентильд харгалзах утгыг авна.
Томьёо	$M_{10} = f(P_{22})$
Ашиглах өгөгдөл	P22 Эшлэлийн тоо P19 Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо




СУДАЛГААНЫ ЧАНАР - RESEARCH QUALITY (30%):

11. Шилдэг судалгаа (Research excellence) (5%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох, салбараар жинлэсэн эшлэлээр шилдэг 10%-д багтах бүтээлийн тоо Энэ үзүүлэлт нь жил, салбар болон ажилчдын тоогоор нормчилсон салбараар жинлэсэн эшлэлийн үзүүлэлтээр шилдэг 10%-д багтах ЭШ-ний бүтээлийн нэг багшид ногдох хувиар тодорхойлогдоно.
Томьёо	$M_{11} = \frac{P_{19}^{Top10\%}}{P_1 + P_4}$
Ашиглах өгөгдөл	P19 Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо P1 Багшийн тоо P4 Эрдэм шинжилгээний ажилтны тоо

12. Өндөр нөлөөтэй судалгаа (Research influence) (5%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох, чухал бүтээлд эшлэгдсэн бүтээл Энэ үзүүлэлт нь эшлэлийн бодит тооноос илүү, хэр “чухал” бүтээлд эшлэгдсэнийг илэрхийлнэ. Тухайн бүтээлийг өөр бүтээлүүд хэр олон дамнан эшлэснээс хамааруулж “чухал” гэдгийг ойлгоно. Нөлөөллийг тооцдог PageRank аргын дагуу судалгааны өгүүллийн дамнасан эшлэлээс хамааруулан PageRank оноог тооцох ба багш болон эрдэм шинжилгээний ажилтны нийт тоонд хуваана.
Томьёо	$M_{12} = \frac{PageRankScore}{P_1 + P_4}$
Ашиглах өгөгдөл	P22 Эшлэлийн тоо P1 Багшийн тоо P4 Эрдэм шинжилгээний ажилтны тоо




ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА - INTERNATIONAL OUTLOOK (7.5%):

13. Гадаад суралцагч (International students) (2.5%):

Тодорхойлолт	Нийт суралцагчдын дотор гадаад суралцагчийн эзлэх хувь Гадаад суралцагчийн тоо нь тухайн улсын хүн амын тооноос хамаардаг бөгөөд их хүн амтай улс нь бага хүн амтай улстай харьцуулахад сөрөг талтай. Иймээс уг үзүүлэлтийг тооцохдоо хүн амын тоог тооцно.
Томьёо	$M_{13} = \frac{P_6 * \log(P_{25})}{P_5}$
Ашиглах өгөгдөл	P5 Суралцагчийн тоо P6 Гадаад суралцагчийн тоо P25 Улсын хүн амын тоо

14. Гадаад багш (International staff) (2.5%):

Тодорхойлолт	Нийт багшийн дотор гадаад багшийн эзлэх үзүүлэлт Гадаад багшийн тоо нь тухайн улсын хүн амын тооноос хамаардаг бөгөөд их хүн амтай улс нь бага хүн амтай улстай харьцуулахад сөрөг талтай. Иймээс уг үзүүлэлтийг тооцохдоо хүн амын тоог тооцно.
Томьёо	$M_{14} = \frac{P_2 * \log(P_{25})}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P1 Багшийн тоо P2 Гадаад багшийн тоо P25 Улсын хүн амын тоо




ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА - INTERNATIONAL OUTLOOK (7.5%):

15. Гадаадтай хамтарсан бүтээл (Int. co-authorship) (2.5%):

Тодорхойлолт	Олон улсын хамтарсан бүтээлийн үзүүлэлт Энэхүү үзүүлэлт нь тухайн байгууллагын нийт судалгааны бүтээлийн хэдэн хувь нь дор хаяж гадаадын эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэсэн болохыг илэрхийлнэ. Тооцоолол нь дор хаяж нэг гадаадын хамтран зохиогчтой бүтээлийн тоог нийт судалгааны бүтээлийн тоонд хуваана. Энэхүү хувьсагчийг тухайн улсын хүн амын тоотой нийцүүлэхийн тулд хүн амын тоогоор нормчилдог.
Томьёо	$M_{15} = \frac{P_{20}}{P_{19}}$
Ашиглах өгөгдөл	P19 Эрдэм шинжилгээний бүтээлийн тоо P20 Гадаадын эрдэмтэдтэй хамтарсан бүтээлийн тоо

16. Гадаадад суралцах (Study abroad) (2.5%):

Тодорхойлолт	Нийт суралцагчдын дотор гадаад улсад солилцоогоор явсан суралцагчийн эзлэх үзүүлэлт Энэ үзүүлэлт нь олон улсын оюутны шилжилт, хөдөлгөөнийг үнэлдэг. Энэ үзүүлэлтийг салбарын жин болон улсын хүн амын тооноос хамааралтай байдлаар авч үзнэ. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор энэ удаад 0 жинтэйгээр авч үзсэн.
Томьёо	$M_{16} = \frac{P_{11}}{P_5}$
Ашиглах өгөгдөл	P11 Оюутан солилцоогоор явсан суралцагчийн тоо P1 Суралцагчийн тоо




ҮЙЛДВЭРЛЭЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР - INDUSTRY (4%):

17. Үйлдвэрлэл, худалдааны орлого (Industry income) (2%):

Тодорхойлолт	Нэг багшид ногдох аж үйлдвэрээс олсон судалгааны орлого. Өнөө үед дэлхийн академик үйл ажиллагааны гол үүрэг нь тухайн салбарт инновац бүтээх, шинэ нээлт гаргах болон зөвлөгөө өгөх үйл явц юм. Энэ үзүүлэлт нь бизнесийн байгууллагууд эрдэм шинжилгээ, судалгаанд хөрөнгө оруулахад хэр зэрэг бэлэн байгааг, мөн байгууллага нь худалдааны зах зээлээс санхүүжилт татах чадварыг илэрхийлнэ – эдгээр нь байгууллагын чанарыг харуулдаг чухал үзүүлэлтүүд юм. Үзүүлэлт нь үйлдвэрлэл, худалдааны зах зээлээс олж буй орлогыг нийт багшийн тоонд хувааж тодорхойлно.
Томьёо	$M_{17} = \frac{P_{18}}{P_1}$
Ашиглах өгөгдөл	P1 Багшийн тоо P18 Үйлдвэрлэл, худалдаанаас олсон орлого

18. Патент (Patents) (2%)

Тодорхойлолт	Нэг судлаачид ногдох патентад эшлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо Энэхүү хэмжүүр нь их сургуулиуд технологи дамжуулах замаар үндэсний эдийн засгаа хэр хэмжээгээр дэмжиж байгааг үнэлэх зорилготой. Патентад эшлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоог багшийн тоо болон эрдэм шинжилгээний ажилтны тооны нийлбэрт хувааж гаргана.
Томьёо	$M_{18} = \frac{P_{21}}{P_1 + P_4}$
Ашиглах өгөгдөл	P21 Патентад эшлэгдсэн бүтээлийн тоо P1 Багшийн тоо P4 Эрдэм шинжилгээний ажилтны тоо





Аргачлал

Ерөнхий алгоритм (хэмжээст оноо)

1. 18 метрик тус бүрийн утгыг нийт сургуулиар тооцоолно.
2. Хамрагдаж буй бүх сургуулиудын өгөгдлийн тархалтыг (гистограм) байгуулна.
3. Хэдэн хувийн прецентильд байрлаж байгаагаас хамаарч оноог хувилна.
4. Нийт 18 үзүүлэлт бүрээр авсан оноог нийлбэрчилж эрэмбэлнэ.

Box-plot vs Histogram



Жишээ (тухайн нэг метрик):


- Авах ёстой оноо: 5
- Метрикийн тооцоолсон утга: 16,7
- Нийт сургуулийн дотор **28.7%**-ийн прецентильд харгалзсан байна.
- Иймээс уг метрикээс авах эцсийн оноо: $5 \times 28.7\% = 1.435$



World
University
Rankings 2025

THE World University Rankings 2025:

4. ЭРЭМБЭ ЗАРЛАХ



Эрэмбэ зарлах

- Эрэмбийн боловсруулалт 4 сараас эхлэн явагдаж 10 дугаар сард үр дүнг зарлана.
- <https://www.timeshighereducation.com/>
- Нэгдсэн эрэмбэд орсон сургуулиудаас тухайн ШУ-ны салбарт тавих нөхцөлийг хангасан бол Салбарын эрэмбэ зарлана.
- Мэдүүлэг өгсөн ч тавих нөхцөлийг хангаагүй тохиолдолд “Reporter” төлөвт жагсана.

Байр, интервал

2025 оны эрэмбийн хувьд:

- Эхний 200 байр тус бүрийн байраар
- 201-250
- 251-300
- 301-350
- 351-400
- 401-500
- 501-600
- 601-800
- 801-1000
- 1001-1200
- 1201-1500
- 1501+



World
University
Rankings 2025

THE World University Rankings 2025:


МУИС-ийн үр дүн

- 2024-03 сард Академик өгөгдлөө мэдүүлсэн
 - 2021-2022 оны хичээлийн жил
 - 2022 оны санхүүгийн жил
- 2024-06 сард шаардлага хангасан тухай мэдэгдсэн
- 2024-10-09-нд “Дэлхийн их сургуулиудын эрэмбэ -2025” зарлагдсан.

МУИС-ийн эрэмбийн үзүүлэлт

RANKING		KEY STATISTICS					
Rank	Name Country/Region	Overall	Teaching	Research Environment	Research Quality	Industry	International Outlook
1501+	National University of Mongolia 📍 Mongolia	10.5– 25.1	14.7	9.2	12.5	20.6	51.0

WUR 2025	
Нийтэлсэн эрэмбэ	1501+
Нарийвчилсан эрэмбэ	1987/2092
Нийт оноо	15.4/100
Эрэмбийн прецентиль	0-5%/100%
Мэдүүлсэн	133 улсын 2860 сургууль
Шалгуур хангаж эрэмбэлэгдсэн нийт сургууль	2092 (WUR2024: 1907)




Салбарын эрэмбэ

Байгалийн шинжлэх ухаан (Physical science)

Subject Ranking	
Нийтэлсэн эрэмбэ	1001+
Нарийвчилсан эрэмбэ	1391
Шалгуур хангаж эрэмбэлэгдсэн нийт сургууль	1447

Байгалийн шинжлэх ухааны салбараар эрэмбэлүүлэх болзол:



Шалгуурын нэр	Босго	МУИС
ЭШ-ний бүтээл:	500+	576
Нийт багшид дунд эзлэх хувь:	5%+	17,5%
Багш нарын абсолют тоо:	50+	140



Байгалийн шинжлэх ухаан салбарт хамаарах дэд салбар

- Mathematics and statistics
- Physics and astronomy
- Chemistry
- Geology, environmental, earth and marine sciences

МУИС-ийн эрэмбийн оноо – 18 метрик тус бүрээр




Гадаадтай хамтарсан бүтээл – хамтарсан улс, үнэлгээ

Шилдэг 20 хамтарсан улс	Хамтарсан бүтээлийн тоо (2019 – 2023)	Нэр хүндийн судалгаа өгсөн үзүүлэлт (2019 – 2024)
Mainland China	137	
United States	135	
Japan	91	1.8
Germany	72	7.2
Russian Federation	71	11.4
France	58	
South Korea	46	
Spain	43	
United Kingdom	40	0.5
Italy	27	
Poland	25	
Canada	24	
Australia	22	0.6
Taiwan	19	
India	17	
Hungary	14	
Netherlands	14	
Austria	12	
Brazil	12	
Czech Republic	12	




Шилдэг 20 хамтрагч улсаас зөвхөн **5 (25%)** нь сүүлийн 6 жилд МУИС-д нэр хүндийн үнэлгээ өгсөн.

Гадаадтай хамтарсан бүтээл ихтэй тул нэр хүндийн судалгаа бөглүүлэх дээр шинэ стратеги хэрэгжүүлэх шаардлагатай.




МУИС-ийн эрэмбийн үзүүлэлтийн харьцуулалт

Их сургууль	Улс	Нарийвчлсан эрэмбэ	Нийтэлсэн эрэмбэ
National University of Mongolia	Монгол	1987	1501+
National Cheng Kung University (NCKU)	Тайван	587	501–600
University of Indonesia	Индонез	834	801–1000
Kanazawa University	Япон	1131	1001–1250
National University of Uzbekistan named after Mirzo Ulugbek	Узбекстан	1191	1001–1250
Incheon National University	Өмнөд Солонгос	1436	1251–1500




- БЯ-ны дэмжлэгтэйгээр THE-с зөвлөгөө авсан
- Улсын сургуулиуд сонгосон
- Багш эсвэл суралцагч ойролцоог сонгосон
- Харьцуулсан бүх сургуулийн үзүүлэлт 5 жилээр хэлбэлзэлтэй
- Узбекстан Их Сургууль анх удаа орсон. 2024 онд репортер байсан.



5 сургуультай харьцуулалт


	Сургалт					Судалгааны орчин			Судалгааны чанар				Үйлдвэрлэлд оруулах хувь нэмэр		Гадаад хамтын ажиллагаа			
	Сургалтын нэр хүнд	Суралцагч – багшийн харьцаа	Докторын болон бакалаврын төгсөгчийн харьцаа	Докторын төгсөгч – багшийн харьцаа	Нийт орлого	Эрдэм шинжилгээний нэр хүнд	Эрдэм шинжилгээний орлого	Судалгааны бүтээмж	Эшлэлийн хэмжээ	Судалгааны чанар	Шилдэг судалгаа	Өндөр нөлөөтэй судалгаа	Үйлдвэрлэл, худалдааны орлого	Патент	Гадаад суралцагч	Гадаад багш	Гадаадтай хамтарсан бүтээл	Гадаадад суралцах
National University of Mongolia	1987	30.5	28.0	0.6	28.1	31.1	14.8	31.7	0.6	12.2	13.2	10.4	15.1	37.8	3.5	30.2	93.9	28.7
National Cheng Kung University (NCKU)	587	71.9	63.4	8.8	85.3	47.0	73.2	99.9	9.4	31.3	36.1	79.5	87.0	100.0	99.7	43.2	23.8	57.8
University of Indonesia	834	99.8	96.6	6.9	29.3	97.2	28.7	77.0	6.2	21.3	10.5	43.9	81.6	99.6	18.3	100.0	10.7	81.9
Kanazawa University	1131	58.8	46.1	3.9	81.9	86.8	48.1	46.2	3.3	25.0	23.7	44.6	63.7	54.4	89.8	35.3	25.3	42.6
National University of Uzbekistan named after Mirzo Ulugbek	1191	45.2	63.7	2.5	33.7	33.6	12.6	38.6	2.8	65.1	68.6	18.1	14.0	53.6	0.5	98.5	47.0	29.0
Incheon National University	1436	33.7	37.7	1.5	59.7	28.5	43.0	45.4	1.9	25.7	40.1	45.9	58.5	36.7	44.6	44.9	32.2	30.3
Metric weights:		2%	5.50%	15%	2.50%	4.50%	5.50%	5.50%	18%	15%	5%	5%	5%	2%	2%	2.50%	2.50%	2.50%

“Гадаадтай хамтарсан бүтээл” хамгийн өндөр хувийн гүйцэтгэлтэй




Сургалттай холбоотой метрик

Сургалттай холбоотой 3 метрик нь
глобал дунджаас доогуур
үзүүлэлттэй



Докторын төгсөгч, бакалаврын төгсөгчийн харьцаа -2%

	Докторын төгсөгч	Бакалаврын төгсөгч	Харьцаа	Хувь	Оноо
University of Indonesia	2844	6704	0.42	99.8	1.996
National Cheng Kung University	343	2366	0.14	71.9	1.438
Kanazawa University	183	1795	0.1	58.8	1.176
National University of Uzbekistan	205	3380	0.06	45.2	0.904
Incheon National University	74	3039	0.02	33.7	0.674
National University of Mongolia	35	2526	0.01	30.5	0.61




2526 бакалавр, 35 доктор төгсгөсөн тул уг харьцаа 0,01 болж байна.

National University of Uzbekistan-тай ижил 0,06 харьцаатай болохын тулд 152 доктор төгсгөх шаардлагатай. (бак төгсөгч тогтмол гэж үзвэл).
Тэгвэл:
Хувиар: **30.5->45.2**
Оноогоор: **0.61->0.904** болж өснө.

Note: ratios are not subject weighted on this slide

Багш, докторын төгсөгчийн харьцаа -5,5%




2022 онд **798 багш 35 доктор** төгсгөсөн. Харьцаа: 0.04.

Incheon National University-тай ижил түвшинд очихын тулд харьцааг 0.09 болгох.


Үүний тулд 72 доктор төгсгөх. Тэгвэл
Хувиар: 28->37,7
Оноогоор: 1,54->2,0735
болж өснө.

Note: ratios are not subject weighted on this slide

Багш, суралцагчийн харьцаа – 4,5%




Энэ харьцаа нь их сургуулиудын стратеги бодлогоос хамаарах хэдий ч бага харьцаатайд их оноо өгнө.



Нэг багш+ЭША-д ногдох бүтээлийн хэмжээ – 5,5%

	Багш	ЭША	Бүтээл	Хувь	Оноо
University of Indonesia	5117	701	18944	28.7	1.5785
National Cheng Kung University	1359	434	17791	73.2	4.026
Kanazawa University	1047	278	9235	48.1	2.6455
Incheon National University	820	122	4708	43	2.365
National University of Uzbekistan named after Mirzo Ulugbek	1014	815	1900	12.6	0.693
National University of Mongolia	798	201	1002	14.8	0.814




Нэг багш+ЭША-д ногдох бүтээл (2019 – 2023)	3	10	7	5	1	1
--	---	----	---	---	---	---



National University of Uzbekistan-тай
ойролцоо байна. 1 багш – 1 бүтээл

Багшийн тоо тогтмол үед:
5 жилд 4734 бүтээл гаргаж байж
Incheon National University-тай ижил
түвшинд очно. Тэгвэл
Хувиар: 14,8->43
Оноогоор: 0,814->2,365 болж өснө.


Бүтээлийн тоо – салбарын ангиллаар






Бүх салбараар бүтээлтэй

	Багш	ЭША	Бүтээл
Overall	798	201	1002
Arts and Humanities	184	14	94
Business and Economics	140	23	50
Clinical and Health	4	8	75
Computer Science	43	3	166
Education	44	20	33
Engineering	49	3	198
Law	63	17	2
Life Sciences	45	10	269
Physical Sciences	140	65	576
Psychology	11	0	11
Social Sciences	75	38	138

Нэг багш+ЭША-д ногдох бүтээл (2019 – 2023)	1	0	0	6	4	1	4	0	5	3	1	1
--	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---



Гадаадтай хамтарсан бүтээлийн эзлэх хувь




Гадаадтай хамтарсан бүтээлийн эзлэх хувь - салбараар


	Overall	Arts and Humanities	Business and Economics	Clinical and Health	Computer Science	Education	Engineering	Law	Life Sciences	Physical Sciences	Psychology	Social Sciences
National University of Mongolia	77%	62%	56%	84%	66%	64%	78%	0%	95%	79%	64%	71%
Peer Median	34%	29%	37%	30%	28%	27%	32%	19%	33%	39%	38%	34%
National Cheng Kung University	34%	29%	37%	32%	25%	31%	31%	32%	33%	39%	49%	34%
University of Indonesia	19%	19%	19%	25%	13%	17%	22%	19%	36%	13%	41%	22%
Kanazawa University	31%	34%	39%	23%	35%	33%	32%	43%	31%	39%	34%	34%
National University of Uzbekistan	44%	22%	37%	44%	28%	8%	51%	0%	68%	43%	33%	23%
Incheon National University	36%	30%	36%	30%	44%	27%	34%	18%	31%	35%	38%	38%



Хамгийн өндөр:
Life Science (95%),
Clinical and Health (84%)
Physical Science (79%).




Гадаадтай хамтарсан бүтээлийн эзлэх хувь - тренд




2017 онд 89% байсан бол
2023 онд 75% болж
буурсан

Source: SciVal (2014-2023)


Гадаадтай хамтарсан бүтээлийн эзлэх хувь - тренд



Харьцуулсан
сургуулиудаас хамгийн
өндөр үзүүлэлттэй




Гадаадтай хамтарсан, хамтраагүй бүтээлийн эшлэл




Хамтарсан бүтээлийн дундаж эшлэл – 9,4
Хамтраагүй бүтээлийн эшлэл – 3,1

Гадаадтай хамтарсан бүтээлийн эшлэл нь хамтраагүй бүтээлээс 3,0 дахин их байна.


Source: SciVal (2019-2023)



Эшлэлийн хэмжээ – 15%




- Харьцуулсан сургуулиудаас хамгийн бага үзүүлэлттэй
- Эрэмбэд 15% эзлэх тул энэ үзүүлэлтэд онцгой анхаарах




*partial data for final year

Судалгааны чанар – 5%


- Салбар бүрээр 75%-ийн прецентильд хамаарах эшлэлүүдээр эрэмбэлнэ.
- Тухайлбал: Физикийн салбарын бүх бүтээлийн хувьд салбараар жигнэсэн эшлэлийн оноо(FWCI)-г тооцоолсны дараа тэдгээрийн вариацийн цувааны 75%-н прецентильд харгалзах утгуудыг авч сургуулиудыг эрэмбэлж, оноожуулна.
- Энэ үзүүлэлт нь судалгааны чанарыг тодорхойлох бөгөөд нийт бүтээлд хэт өндөр болон хэт бага эшлэгдсэн өгүүллүүдийн нөлөөг үл харгалзах зорилготой.



Судалгааны чанар – 5%




- Салбараар жинлэсэн эшлэлийн оноо(FWCI)-ны 75%-ийн прецентильд хамаарах утга





Шилдэг судалгаа


- Салбарын эшлэлийн хэмжээгээр шилдэг 10% д багтах эшлэлтэй бүтээлийн тоо (FWCI – салбараар жинлэсэн эшлэлийн оноогоор тооцно)
 - Он, салбар, багшийн тоонд нормчилно.




Шилдэг судалгаанд харгалзах гүйцэтгэлийн хувь




Өндөр нөлөөтэй судалгаа – 5%



- Олон талт эшлэлтэй бүтээлийн тоо (FWCI)
 - Өөрийн эшлэлээс илүү бусдын эшлэлийг илүү үнэлнэ.
 - PageRank эрэмбэлэх аргачлалын дагуу тодорхойлж, багш+ЭША-ны тоонд нормчилно.






A circular inset image showing a perspective view down a long, well-lit library aisle. On both sides are tall wooden bookshelves filled with books of various colors. The floor is made of light-colored square tiles. The aisle leads towards a bright light source at the far end, creating a sense of depth.

Эшилсэн бүтээл → Эшлэгдсэн бүтээл

Research Influence - Universities

- In Computer Science in 2022:
 - University X has a set of papers with 1000 citations, all from University Y
 - University Y has a set of papers with 900 citations, all from University X
 - Papers from X & Y universities do cite other universities papers
 - University Z has a set of papers with 800 citations, from universities around the world, including universities who receive over 10000 citations for all their papers
- **Papers from University Z had the least citations, but it is the most influential university of these 3**



Research Influence – How it works

Papers start with the same influence


We can then think of some of a papers influence being shared amongst the papers it cites

This process is repeated multiple times through a number of iterations (page rank is an iterative algorithm)


The effect is that papers that are well connected receive more influence scores than from papers that aren't

This is then rolled up to the university level to calculate university influence

The diagram shows the effect at university level which is an aggregation of the papers produced by the university; this is done to aid understanding. The algorithm works at the paper level.





Deeper Red indicates more Research Influence



Патент -2%

Их сургуулийн судалгаанаас иш татсан патентын тоо, Багш+ЭША тоонд нормчилно.



Судалгааны бүтээл нь патентад хэр эшлэгдсэнээр тодорхойлогдоно.


- Багш+ЭША-ны тоонд нормчилно.
- Салбар бүрээр өөр жинтэй
- 5 патент оффисын 43 сая патентыг ашиглаж байна.
 - World Intellectual Property Organization (WIPO);
 - European Patent Office (EPO);
 - US Patent Office (USPTO);
 - Japanese Patent Office (JPO);
 - UK Intellectual Property Office (IPO.GOV.UK)

Гадаад хамтын ажиллагаатай холбогдох метрик

- Шууд харьцаа бодох нь их хүн амтай улсуудад сөрөг нөлөөтэй тул тухайн улсын хүн амын тоог харгалзаж үзнэ.
- Гадаад суралцагч, гадаад багш, гадаадтай хамтарсан бүтээлийг тооцохдоо хүн амын тоонд нормчилно.
 - Жишээ: “Гадаад суралцагч” метрикийн хувьд

$$(\text{гадаад суралцагчийн тоо} * \log(\text{улсын хүн амын тоо})) / \text{нийт суралцагчийн тоо}$$


- Үзүүлэлт тус бүр 2,5% жинтэй
- Ковид-19 цар тахлын улмаас 2020-2021 оны хичээлийн жилээс оюутан солилцоо багассан тул түр хугацаагаар “Гадаадад суралцах” метрикийг 0 жинтэйгээр авсан.





Гадаад багш – 2,5%, гадаад суралцагч – 2,5%

	Гадаад багш	Хувь	Оноо
National University of Mongolia	3%	30.2	0.755
University of Indonesia	60%	100	2.5
National University of Uzbekistan named after Mirzo Ulugbek	37%	98.5	2.4625
National Cheng Kung University (NCKU)	7%	43.2	1.08
Kanazawa University	4%	35.3	0.8825
Incheon National University	7%	44.9	1.1225

	Гадаад суралцагч	Хувь	Оноо
National University of Mongolia	2%	28.7	0.7175
University of Indonesia	18%	81.9	2.0475
National University of Uzbekistan	2%	29	0.725
National Cheng Kung University	12%	57.8	1.445
Kanazawa University	6%	42.6	1.065
Incheon National University	3%	30.3	0.7575





Гадаад багш, гадаад суралцагчийн харгалзаа



Орлоготой холбоотой метрикууд – нэг багшид ногдохоор


Нийт орлого – 2,5%
ЭШ-ний орлого – 5,5%
Үйлдвэрлэл, худалдааны орлого – 2%



Нэр хүндийн судалгаа



- 2023, 2024 оны асуулгыг тооцно.
- МУИС-д 29 судлаач санал өгсөн
 - Гадаадаас-24
 - Өөрийн улсаас-5
- Сургалт
 - Хувиар: 0.6% (100%-с)
 - Оноогоор: 0.09 (15-с)
- Судалгаа
 - Хувиар: 0.6% (100%-с)
 - Оноогоор: 0.108 (18-с)
- WUR2025-д 10%-ийн self-voting зөвшөөрсөн.
- Саналын тоо, саналын агуулгаас хамаарна.





Нэр хүндийн судалгаа

	2020	2021	2022	2023	2024	YoY change (2023 vs 2024)
National Cheng Kung University	150	91	204	185	269	45.2%
University of Indonesia	46	43	91	139	180	29.7%
Kanazawa University	15	14	39	53	120	127.0%
National University of Uzbekistan	0	10	43	44	85	95.9%
Incheon National University	6	0	15	30	54	78.4%
National University of Mongolia	1	0	1	6	23	257.2%

2023+2024 онд нийт 29 санал

- Судалгааны – 17, Сургалтын – 12
- Гадаадаас – 24, Өөрийн улсаас - 5





Нэр хүндийн судалгаа

	2020	2021	2022	2023	2024	YoY change (2023 vs 2024)
National Cheng Kung University	150	91	204	185	269	45.2%
University of Indonesia	46	43	91	139	180	29.7%
Kanazawa University	15	14	39	53	120	127.0%
National University of Uzbekistan	0	10	43	44	85	95.9%
Incheon National University	6	0	15	30	54	78.4%
National University of Mongolia	1	0	1	6	23	257.2%

2023+2024 онд нийт 29 санал

- Судалгааны – 17, Сургалтын – 12
- Гадаадаас – 24, Өөрийн улсаас - 5



THE: SWOT шинжилгээ



Давуу тал

- Гадаадтай хамтарсан бүтээл хамгийн өндөр үнэлгээтэй.
- Нэр хүндийн судалгааны тоо өссөн

Сул тал

- Харьцуулсан 5 сургуулийн хувьд дийлэнх үзүүлэлт бага.
- Монголоос өгсөн нэр хүндийн судалгаа бага.
- Гадаадтай хамтарсан бүтээл буурах хандлагатай

Боломж

- Бүтээлийн тоог улам нэмэгдүүлэх
- Нэр хүндийн судалгааг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэл, худалдааны орлого өндөр байгааг патенттай уялдуулах боломжтой

Аюул

- Эрэмбэд орох сургуулийн тоо жил бүр нэмэгдэж буй тул зарим тогтмол байх үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн хувьд дараа жил буурч үнэлэгдэх ирэх магадлалтай. Иймд бүх үзүүлэлтийг онцгойлон авч үзэх шаардлагатай.

- МУИС нь дэлхийн түвшинд анх удаа эрэмбэлүүлж байгаа бөгөөд цаашдын стратегийг эрэмбийн шалгууруудтай уялдуулан тодорхойлох
- Судалгааны бүтээлийн тоо, чанарыг сайжруулахыг зорих
- Бүтээлийн түгээн дэлгэрүүлэлт, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар гадаадтай хамтрах бүтээлийн тоо, судалгааны нэр хүндийг нэмэгдүүлэх
- Нэр хүндийн судалгаанд дотоодын эрдэмтэд бага хамрагдсаныг анхаарч, түгээн дэлгэрүүлэлтийг нэмэгдүүлэх
- Судалгааны орлого харьцангуй сайн байгаа бөгөөд түүнийг аж үйлдвэрлэлтэй холбох буюу үйлдвэрлэл, худалдаанаас олох орлогыг нэмэгдүүлэх, патенттай холбогдох метрикийг нэмэгдүүлэх стратеги хэрэгжүүлэх



World
University
Rankings 2025

Thank you!



Times
Higher
Education